

**ХОВД АЙМГИЙН МӨНХХАЙРХАН СУМЫН “ОВОР”
БАЯНДЭЛЭГИЙН ТУХАЙ АМАН ТҮҮХ, АМАН УЛАМЖЛАЛ
ХИЙГЭЭД 1944-1990 ОНЫ ХООРОНДОХ АЛТАЙН
УРИАНХАЙЧУУДЫН ШАШИН ШҮТЛЭГИЙН БАЙДАЛ**

Монгол судлаач Ондрей Срба / Ondřej Srba
(БНЧУ-ын Масарикийн Их Сургууль)

Өгүүллийн товч. Алтайн Урианхайн Баруун гарын сул амбан, Дархан гүн, бэйсийн хошууны нутаг, 1929 оноос Мөнххайрхан сумын нутагт амьдарч байсан С. Баяндэлэг (1891–1967) гэдэг хүн өнөөгийн Ховд аймгийн Мөнххайрхан, Баян-Өлгий аймгийн Булган сумын аман түүхэнд элбэг дурдагдаж яригддаг хүмүүсийн нэгэн атал орон нутгийн түүхэнд холбогдох ном зохиолд түүний тухай сураг занги бараг алга байна. Тийм боловч жинхэнэ нэр нь умартагдтал олны дунд “Овор хөгшин” буюу “Овоо ах” хэмээн алдаршсан тус хүн насаараа Мөнххайрхан уул нурууны өндөр салаануудаар, малчин ард түмнээс ч харьцангуй хол орогнож, ер бусын мэдлэг чадвараараа олон хүнд тус хүргэж байсан гэж уг нутгийн хүмүүс бүгдээрээ мэднэ. Энэ хүнийг лам, зоч, номч, мэргэн хүн гэх зэрэг үгээр тодотгодог боловч жинхэнэ дүр нь тодорхойгүй, аман түүх, аман уламжлалын олон хувилбараар бүтээгдсэн домог зүйн шинжтэй түүхийн дүр нь аяндаа бүтээгдэж байгаа явц нь илт харагдаж байна.

Тус илтгэлд Мөнххайрхан, Булган сумын суугуул иргэдээс сурвалжилж авсан тус хүний аман түүх, аман уламжлалын олон дүрст ойлголтыг харьцуулан үзэж танилцуулахаар зорьж байна. Аман түүхийн үндсэн дээр “Овор” Баяндэлэгийн намтрыг миний бие анх удаа 2011 онд бичээд нийтлүүлж байснаас² дахиад арван жилийн хээрийн шинжилгээний явцад баяжуулсан материалыг энд танилцуулна.

1. Оршил

Монголын Ойрд ястнуудын нэг болох Алтайн Урианхайчууд Баруун Монголын өргөн уудам Алтайн нуруугаар нутаглаж 20-р зууны ээдрээтэй хөгжил хувирлын бартаат замыг туулаад өнөөг хүрчээ. 20-р зууны эхний хагаст Алтайн Урианхайчуудын үндсэн нутаг хоёр улсын харья болж хагаслахад хүрч, 1920, 30-аад оны үеийн улс төр, нийгмийн хөгжлийг дагаж ихэнх нь хил давсан нүүдэлд оролцон, дайн дажинд нэрвэгдэх, байгалийн гамшигт мал хөрөнгөө алдах, их хэлмэгдлийн үед хуучин нийгмийн сэхээтний төлөөлөл болох ноёд

¹ This publication was made possible with the support of the Czech Science Foundation within the project GA19-07619S: Mongolian ritual manuscripts in a Czech collection: their edition, history and Central Asian roots.

² Srba, Ondřej – Gegeenhas. 2011. Nome' Bayandeleg (1891–1967): The oral history of a mysterious hermit from Mönhhairhan. *Mongolo-Tibetica Pragensia* '11 4/2, x. 69–91.

жүүуртан, лам хуврагаа алдаж, сүүлд үндсэн нутагтаа үндэсний цөөнх болтол ажармаатай замаар явсан ч өнөөдөр хүртэл асар хэмжээний соёлын өв хадгалж чадсан тийм ард түмэн юм аа.

Алтайн Урианхайн долоон хошууны хамгийн баруун зүгт оршиж байсан баруун гарын сул амбаны хошуу буюу Дархан гүн, бэйсийн хошууны нутаг өнөөгийн Ховд аймгийн Мөнххайрхан, Дуут, Баян-Өлгийн аймгийн Булган, БНХАУ-ын Шинжаан УӨЗО-ны Чингэл сиян зэрэг газруудыг хамарч байжээ. Тус хошуу 18-р зунаас үүдэлтэй хошууны нэг хүрээ, тамгагүй хоёр хувилгаан, 1920-оод оны эхэнд төв хүрээнээсээ салбарласан хоёрдогч бага хүрээтэй болов.³ Хурал номын ажил анх удаа 1930 оны хил давсан нүүдэлд нэрвэгдэж, 1932-1934 оны буцах нүүдлээр лам нарын нэг хэсэг Шинжаанд үлдэж, нэг бүлэг лам, банди нар нүүдлийн явцад харлаж хүрээнээсээ салцгаав. Тэгсэн ч хоёр хүрээ 1937 он хүртэл ажиллагаа явуулж байгаад 30 орчим лам цаазлагдаж, харьцангуй цөөн тооны лам, банди харлаж малчин болж нутагтаа цаашаа амьдарч байжээ.

Баян-Өлгий аймгийн Булган суманд хэлмэгдлийн дараах үед амьдарч байсан лам Намрал (1910-1984), С.Равжаа (1901-1970) нар номын үйлсийг ардын засгийн үед авч явж байжээ. 1990-өөд он хүртэл амьд байсан настай лам нарын дунд бага умзад гэлэн Баяндаан Жалцан, гэлэн Д.Доноров, С.Пунцаг, Н.Таяа, Дамчаа, Чойндон, гэцэл Жигмэд, Ч.Чойдор, М.Хуушаан, манж Цогтын Содов, Х.Чүлтэм, Б.Пэрлэй, М.Сунгарав, Х.Норжоон, Олзтой, Шилэг, Л.Гонжоо, Б.Лөр, М.Намдаг⁴ зэрэг хүрээнд шавилсан хүмүүс сүсэгтэн олны хүслийн дагуу нууцаар номын ажил явуулдаг байгаад 1990-өөд оны үед эхлээд гэр дуган, дараа нь байшинтай сүмийг бариулж, тогтмол номын ажлыг сэргээсэн билээ.

Бага хүрээ Мөнххайрхан сумын нутагт Алгын аманд тараад дийлэнх лам нь эсэргүүнд баригдсаны сүүлээр Суудлын Гүнсэл, Пайзын Чоймбол зэрэг хэлмэгдлээс үлдсэн лам нар ба тэдний дунд голдуу Чойсүрэнгийн Риймэд лам цаашид номын ажлыг явуулж байгаад төвд номын уншлага, шашны зан үйлээ хүү Балданжавт өвлүүлсэн бөгөөд тэр бээр залгаад өөрийн хүү Цэрэн-Адьяаг шашны номд сургаж лам болгов.⁵ Төвд номыг эцгээсээ хүүд дамжуулж чадсан

³ Б.Баатарын тэмдэглэснээр (Баатар, Б. 1999. *Булган нутгийн буянтай буурал*. Булган, х. 17, 19) Их хүрээг Дашчойнхорлин, Бага хүрээг Дашбалжирлин гэдэг байв. Р.Балданжавын бичсэнээр Их хүрээг Дашбалжорлин, Бага хүрээг Дашпэлжээлин гэдэг байв. (Балданжав, Р. 2016. Урианхайн Дашчойнхорлин хийдийн өнөөгийн байдал. In: *Баруун Монголын шашин соёл*. Эмхэтгэж, эрхлэн хэвлүүлсэн На.Сүхбаатар, Г.Ядамжав. Улаанбаатар: Тод номын гэрэл төв, х. 180.)

⁴ Өөрийн хийсэн хээрийн шинжилгээний тэмдэглэл хийгээд Б.-Ө. аймгийн Булган сумын Б.Баатарын бичсэн "Гэр дуган нээж хурал хурав" 1990.12.11. Аймгийн сүсэгтний зөвлөлд явуулсан мэдээлэл. (Баян-өлгий аймгийн сүсэгтний холбооны архив. Раашин чойлин хийд сүсэгтний холбооны санхууны болон баримт материал).

⁵ Балданжав, Р. Урианхайн Дашчойнхорлин хийдийн өнөөгийн байдал, х. 180.

энэхүү гэр бүлээс гадна тод үсэг сурч, тод үсгийн ном судрыг уншдаг байсан хар хүнээс Мөнххайрхан суманд Жамъядай, эмэгтэй Санжийн Наадгай, Булган суманд Түрүүний Тогтох, түүний охин Дамдины Муужаа нар амьдарч байжээ.⁶

2. *Баяндэлэгийн залуу нас, эрдэм чадлын үндэс.* 2010 онд намайг Мөнххайрхан суманд аман түүхийн судалгаагаар анх очиход 1960-аад он хүртэл Мөнххайрхан сумын Борт багийн нутаг Баянсай гэдэг газарт амьдарч байсан Овор гэх өвгөн хөгшний тухай яриа миний анхаарлыг ихэд татав. Энэ хүний жинхэнэ дүр нь тодорхойгүй атал хүмүүсийн аман мэдээгээр тус нутгийн иргэд энэхүү хүнийг шүтдэг, шашны зан үйл, тусламж үйлчилгээ түүнээс эрдэг байсныг бодвол Овор гэдэг хөгшин бол Мөнхайрхан суманд сүм хүрээ тарснаас хойших үеийн ардын дундах шашин шүтлэгийн чухал төлөөлөгч болох юм аа.


Өндөр ууланд зуслангийн бүсээс ч өндөр дээд газарт нутагладаг энэ хүнийг тухайн үед таньдаггүй хүн гэж энэ суманд байгаагүй боловч түүнтэй ойр дотно явсан хүн бол харьцангуй ховор байсан. Үүнээс болж энэ хүний намтар түүх, үйл ажиллагааны тухай олон зүйлийн яриа гарч байсан нь, улам дамжигдсаар домог зүйн шинжтэй болж эхэлсэн юм.

Олны өгсөн нэр болох Овор гэдэг нэрээр одоо дурсагддаг энэ хүний жинхэнэ нэр Баяндэлэг гэж байв. Зарим хүмүүс Овоо, Овой ах гэж авгайлдаг. Одоо энэ хоч нэрийг ихэнх хүн “онцгой сайн, мундаг, өвөрмөц байдалтай” гэсэн утгаар ойлгодог болсон ч Б. Ханджавын тайлбарласнаар Овор өөрөө “Очир тамын амыг сахисан Овгор чулуу толгойт хаан” гэсэн үлгэрийг ярих дуртай байсан тул тэгж хочлогдсон байна гэнэ.

Аман мэдээнд үндэслэхэд энэхүү Овор гэгдэх хүн тус хошууны нутагт 1892 оны луу жил Сорсгор хочтой Жамсран гэдэг хүний Баяндэлэг нэртэй хүү болж мэндлэв. Эцэг нь Алтайн Урианхайн Зүүн гарын Мэйрэнгийн хошууны нутаг болох одоогийн Алтанцөгц сумын хүн байгаад залуудаа ирээдүйг зөгнөх чадалтай авга эгчийнхээ зааврын дагуу Мөнххайрхан ууланд ирж нутаглажээ. Сорсгор Мөнххайрхан ууланд ирж айл гэр бүл болоод хөх сарлагийн томоохон сүрэгтэй болж баяжив. Нэг өдөр түүний хотонд хар бяруу орж ирэхэд Сорсгор хар зүсмийн үхэр нэмж өсгөн үржүүлэх санаатайгаар түүнийг сүрэгтэй оруулаад, удахгүй бүх малаа үхүүлж, “Луусын заяасанд буянд бузар оруулж. Ихийг бодохоор багын хишиг зайлна” гэсэнчлэн гар хоосон юу ч үгүй хоцров. Түүнээс болоод түүний үр удам ч дахиад баян болж чадаагүй гэж Овор өөрөө ярьдаг байжээ.⁷

⁶ Срба, Ондрей. 2018. Монгол улсын Алтай Урианхайчуудын тод үсгийн хэрэглээ (Аман түүхийн судалгаа). In: *Тод үсэг* – 370. Улаанбаатар: Тод номын гэрэл төв. х. 24-34. – Срба, Ондрей. 2015. A Collection of Clear Script Manuscripts of S. Naadgai and the Continuity of Clear Script Usage in Oirat Religious Life. In: *Linguistica Brunensia* 63/1 (2015), х. 37-56.

⁷ Мөнххайрхан сумын өндөр настан Б.Ханджав (1926–2017), Баянсай, 2012.7.5., бичлэгийн дугаар WS560661, 11:13–14:39.



“Овор” Баяндэлэгийн ургийн бичгийн схем.

Баяндэлэг хорь гаруй насандаа Жаа лам Дамбийжалцаны цэрэгт татагдав. Баруун хязгаарын бүх хошуу Жаа ламын цэрэг, түүний шавь цөөнгүй хүн, айлыг өргөж байсан ч Алтайн Урианхайн Дархан гүний хошуунаас өргөсөн шавь цэргийн тоо бага байсан гэж аман уламжлал өгүүлж байна. Архивын бичиг баримтын дунд ч Алтайн Урианхайн Дархан гүний хошуунаас Дамбийжалцанд өргөсөн хүмүүсийн жагсаалт ер олдсонгүй. Баяндэлэгийг Жаа ламын цэрэгт байхад түүний цэргийн анги Дунд Сэнхэрийн аманд байгаад Жаа ламыг тухайн үед Оросын төлөөлөгчид баривчилсан тул цэрэг нь мөн тэндээс тарсан гэв. Одоо хүртэл тэр газарт Жаа ламын цэргийн буур гэж байдаг.

Жаа ламын цэргээс халагдаж ирээд Баяндэлэг эгчийнхээ нөхөр Увс аймгийн гаралтай Халтар хочит зоч ламыг дагаж түүнээс зоч ёсны лүйжин номыг тэргүүтнийг сурч авсан юм. Баяндэлэг хүргэн ахыгаа их номтой хүн бөгөөд түүнийг нутгаасаа хол явсан, ядуу, бадарчин хүн тул ном эрдмээрээ танигдаж чадаагүй гэж ярьдаг байсан гэв.

[Овор ах хүргэн ах Халтар зочийн тухай ярихдаа]: Ном хялцаад давтдаг хүн байдаггүй [болохоор] хавчиг үүрэг гэж юм тааруулж аваад явган гүйгээд нутаг хошуу цугийг хэсээд, тэгээд яваад яваад байж [байгаад манай нутагт ирсэн]. Манай Урианхай гүртэм хамба гэж нэг их архи уудаг тийм хүн байжээ. Тэр тийм хүнд очиж үзсү [=үзье] гэж бодоод манай Урианхайн баруун амбаны бага хүрээ гэдэгт ирдэг юм. Тэгээд сууж байтал гэр өргөө байрыг нь заалгаж аваад сууж байтал ийм ширмэл ширдэг байсан юм даа, тэндээр [Халтар зочийг] суулгаж байтал [гүртэм хамба] шал согтуу юм амьтан дамжилж орж иржээ. Одоо [нэг нь] гүйж явсан цагаачин лам болно, бадарч, [нөгөө нь] хошууны нэр хүндтэй лам болно. [Тэгээд Халтар зоч ламаас]: “Амар мэнд ээ.” [Гүртэм хамба]: “Чи надтай чадал үзсү гэж

ирэв үү чи? Задарсан бадарч, заяаны чинь хань Сэнхэр газарт⁸ байна. Авгай ав, хөвүүн гарга, адал [мал] хадгал” гээд тэгэхээр одоо [Халтар зоч] ямар ч нэр төргүй, нутаг хошуундаа зөвшөөрөлгүй, биеэ [=өөрөө] ямар номтой эрдэмтэй боловч сул гүйж явсан бадарч болно, тэр [гүртэм хамба] хошууны хүрээний том лам болно. Тэр хүний дур багадаад, дуугүй гарсан. Тэгээд явж яваад манай эгчийг аваад найман хөвүүтэй болсон гэж [Овор ах хэлэв]. [Овор] тэр зоч тэр хүргэн ахаас бичкэн [=жаахан] юм сурсан юм байлаа.⁹

Баяндэлэгийн өндөр насанд нь түүнтэй ойр дотно явдаг байсан Банзарын Ханджав гуай түүнийг угаасаа авгай авах дур хүсэлгүй, номын ёсоор явж байсан хүн гэж үзэж байв. Учир нь тэр өөрөө авгайтай суувал “хэрэлдэнэ, хэмхэлдэнэ муу юм хэлцнэ”¹⁰ гэж нүглээс айх учраас авгай авах дургүй байв. Гэхдээ үүнээс ялгаатай нэгэн хувилбар бас Мөнххайрхан суманд ихэд дэлгэрсэн байгаа. Үүний дагуу Баяндэлэг залуу насандаа баян айлын охинтой сэтгэлтэй болоход баян айлын эцэг эх охиноо түүнтэй суулгахгүй учраас охин нь Бортын Шажин гэдэг газарт хаднаас өөрийгөө боомилж хорлосон гэдэг. Баяндэлэг үүнд өөрийгөө гэмтэй гэж үзээд, үүнээс болж дахиад өөр хүнтэй суухгүй гэж шийдээд нас эцэстлээ гав ганцаараа амьдардаг болсон бөгөөд үнэнч сэтгэлээ илэрхийлэхийн төлөө хайрт амрагийнхаа амиа хорлосон газраас ер онц холдохгүйгээр байрладаг байжээ.¹¹

3. Хил давсан нүүдлийг Баяндэлэг хэрхэн эсэргүүцсэн тухай. 1930 онд тус хошууны ард түмний ихэнх хэсэг сумын занги нараараа удирдуулан тухайн үед нэгэнтээ тогтсон улсын хилийг давж хуучин нутаг нь болох Алтай Чингэл буюу Шинжаан мужийн газарт нүүгээд явцгаав. Хошуу ноён, занги нарын гэр бүл, төрөл саднаас гадна хүн амын дийлэнх хувь 1932–1934 оны хооронд зудад нэрвэгдсэний улмаас малаа ихээхэн хэмжээгээр хорогдуулаад буцаж ирэв. Баяндэлэг энэ үед нүүдлийн хандлагад автаж нүүгээгүй, Мөнххайрхан ууланд хэвээрээ үлдэж хоцорсон гэв. Баяндэлэг өөрөө “нүүх хэрэггүй, хамаг

⁸ Алтайн Урианхай Баруун амбан буюу Дархан гүн, бэйсийн хошууны нутгийн зүүн хойт хэсэгт Мөнххайрхан уулнаас эх авдаг Хойд, Дунд ба Хуурай Сэнхэр буюу Цэнхэр гол байдаг тул тус газрыг нийтэд нь “Сэнхэр газар” гэж хэлдэг. Одоо Ховд аймгийн Дуут, Мөнххайрхан, Манхан сумын нутаг.

⁹ Мөнххайрхан сумын өндөр настан Б.Ханджав, Баянсай, 2012.7.5., бичлэгийн дугаар WS560661, 03:15–05:16.

¹⁰ Мөнххайрхан сумын өндөр настан Б.Ханджав, Баянсай, 2012.7.5., бичлэгийн дугаар WS560661, 22:20.

¹¹ Энэ түүхийг жишээ нь Мөнххайрхан сумын малчин Довдоний Очир Овортой Жаа ламын цэрэгт хамт явж байсан Пэрлээ гэдэг хүнээс сонсов гэсэн. Их Хотгор зуслан, бичлэгийн дугаар WS560651, 2012.6.29.: Тэр хөгшин бол гэр бүл больё гэгээд ганцхан хүүхэнтэй танилцсан байна. Тэгээд тэр хүүхэн тэгий, [гэвч] хүүхний аав ээж тэр хөгшинтэй суулгахгүй, тэр залуутай суулгахгүй, өшөө хүнтэй суулгана гэж хавчаад тэгээд тэр хүүхнээ өгөхгүй болохоор тэр хүүхэн одоо боомилоод нас барчихсан. Энэ Шажинь Усан зайлдаг гэдэг газарт хаданд дүүжлэгдээд нас барчихжээ тэгээд тэрнээс хойш [Овор] ерөөсөө эмэгтэй хүнд ойртохгүй тэгээд ганцаараа насаа төгсгөсөн тийм хүн.

малга бараад ирнэ” гэж хил давж нүүхээс бусдыг ятгаж байсан гэнэ.¹² Бараг айл, хүнгүй болсон ууланд өөрөө малгүй байсан ганц бие хүн яаж амьдарснаа өөрөө “ууланд хоцорсон сарлагийн бух алж, тарвага агнаж байгаад амьдарсан” гэж хэлэв.¹³ Харин нутгийн нь өөр хүмүүс түүнийг мал огт агнадаггүй мөртлөө шууд Алтайн эзэн савдгаас хоол хүнс олдог гэж үздэг байсан юм. Үүний тухай С.Балдаа дурдахдаа:

Би бүтэн гайхсан. Гурван жил [манай нутгийн хүмүүсийг] яваад ирэхэд тэр хүн [Овор Баяндэлэг] амьд байлаа гэнэ. Нутаг цуг байхгүй. [Овор] ан алдаг хүн бас биш. Тэр их хачин, тийм хүн байсан.

Энэ ийм учиртай миний хөвүүн. Цаст цагаан уулыг чи үзвүүч? Дээр гучин гурван хаан хурмаст гэж манай энэ монгол хүний залбирал энэ. Дээр гучин гурван хаан хурмаст, доод далан долоон луст, Алтайн таван дээдэс минь, бурхан багш минь, Цаст цагаан уулын Гилээн өвгөн,¹⁴ Хүрэн улаан уулын Хүүхэн савдаг гэж залбирдаг юм.

Тэр хүнийг байшдээ, тэр Цаст цагаан уулын Цагаан өвгөн, Хүрэн улаан уулын Хүүрэн улаан савдаг тэжээж байсан юм байхгүй юү? Тэгээд юмаар дутахгүй, гурван жилийн дотор тэгээд юмаар дуталгүй байсан байхгүй юү? Нутаг цуг хоор [=хойш, баруун тийш буюу Шинжаанд] явсан, [энд] нэг айл [ч] байхгүй [байсан үед Овор энд ганцаараа үлдсэн]. Хулгай хийдэггүй, худал хэлдэггүй, тэндээ нам хоттой хоолтой сайхан байсан, [нутгийн ард түмнийг] гурван жил яваад ирэхэд. ... [Овор бол] Алтайн савдаг[ийн] халайсан [харсан] хүн болно бишүү. Шулман биш Алтайн савдаг халайсан, тэгээд нууц байхгүй юү?¹⁵

1940, 1950-аад оны үед Баяндэлэг шинэ төр, нийгмийн зохион байгуулалтын цаашдын хувирлыг зөгнөн үнэлэхдээ “энэ их ядарсан зүдэрсэн амьтанд их буян ирнэ, тэр [бол] хилэнцийн буян. Энэ малгүй хүн цөм малтай болно. Гэвч хүний малыг ямар ч үнэ өртөггүй цөмийг туугаад [авбал бас болохгүй учир] түүнийг

¹² Мөнххайрхан сумын уугуул Д.Батсуурь, Ховд аймгийн төв, 2013.7.24., бичлэгийн дугаар WS561004.

¹³ Мөнххайрхан сумын уугуул Д.Батсуурь, Ховд аймгийн төв, 2013.7.24., бичлэгийн дугаар WS561004. Үүний тухай бас Мөнххайрхан сумын малчин Д.Очир, Их Хотгор зуслан, бичлэгийн дугаар WS560651: *Залуудаа ан хийдэг байсан гэлээ, тарвагнаас анги юм алж байгаагүй хэвтэй.*

¹⁴ Алтайн Урианхайчууд “цагаан” гэдэг үгийг цээрлэж “гилээн” (гялаан) гэсэн үгээр орлуулж хэрэглэнэ.

¹⁵ Булган сумын малчин, анчин С.Балдаа (1933–2015), Гүүтийн ам, 2012.5.11., бичлэгийн дугаар WS560603, 46:23. Алтайн Урианхайчуудын өгүүлж байгаагаар хүн Алтайн савдагтай уулзвал үүний тухай хэнд ч хамаагүй хэлж болохгүй, хэлье гэвэл олон жилийн дараа юм уу, нас барахаасаа өмнө хэлж болно.


"БНМАУ: Буддын шашин, сүм хийдийн асуудал" (1944-1990 он)

хилэнцийн буян" гэж байв. Гэхдээ энэ бүх мал дахиад эзэн эзэндээ ирнэ гэж нэгдэл тарах ирээдүйн цагийг зөгнөн ярьдаг байжээ.¹⁶

4. 1940, 1950-аад оны үеийн Баяндэлэгийн амьдралын хэв маяг. Энэ үеэс хойш Баяндэлэг бусад айлаас холхон зайтай, айл буудаггүй уулын дав, өндөр салаанд тооногүй хана унь хоёроор барьсан дэглээ, хожим нь хатгуур буюу хана тэрэмгүй урц маягийн гэрт байрлаж, нэг хүрэн гүүнээс өөр малгүй, хожим нь гүүнээс нь төрсөн 5, 6 юм уу 7, 8 хүрэн юм уу зээрд морьтой болов. Дөрвөн улирал дагаж нүүдэггүй, өвөл зунгүй нэг л газарт тогтмол байгаад дур нь хүрэхээр ойр орчмын айлаар орж хэвтдэг байсан гэдэг.

Түүнийг айлд байхал элдэв хэрэгцээтэй хүмүүс түүнийг эрж тусламж, зөвлөгөө асуудаг байв. Овор хүнийг үлээдэг, барьдаг, өвчин зовлонгийн учир шалтгааныг тодорхойлж хэлдэг байв. Хүүхдийн өвчинд онцгой сайн тусалдаг байсан гэнэ. Хүүхэд гаргаж чаддаггүй айлд тус үзүүлж хүүхэд гаргадаг, эрэгтэй хүүхэд төрдөггүй айлд хүү төрүүлдэг, хүүхэд тогтдоггүй айлд хүүхэд тогтоодог байсан гэнэ. Мал амьтан учир мэдэгдэлгүй алдаж үхэж байвал учир шалтгааныг нь тогтоож, саад бэрхшээлийг арилгах чадалтай байсан гэж хүмүүс хэлдэг.

Түүний байрласан газруудыг Б.Ханджав тэргүүтэн өндөр настангуудаас он цагийн дэс дарааллаар сурвалжилж үзсэн бөгөөд газрын зурагт тэмдэглэвэл ийм болов уу.



Зураг 1. "Овор" Баяндэлэг байрлаж байсан газруудын зураг

¹⁶ Мөнххайрхан сумын уугуул Д.Багсуурь, Ховд аймгийн төв, 2013.7.24., бичлэгийн дугаар WS561004, 11:40.

Овор ах нэг зээрд морио унаж нэгийг хөтөлж бусдыг зүгээр ардаа дагуулж
ж ийм дүрээр түүнийг нутгийн ихэнх хүмүүс дурсан санадаг байна.
С.Балдаагийн мэдээлснээр 1930-аад оны үед Мөнххайрхан суманд хэлмэгдсэн
иргэдийн хөрөнгө хураах үед нэг Казах айлын хүрэн гүүг Оворт өгчээ.¹⁷ Өөр
хүний хэлснээр Овор энэ гүүг ямар нэг хүнд тусалсны өргөл барьц маягаар олж
авав. Балдаа гуай Овор ахтай 1961 онд уулзахдаа “Овор ер нь морь унадаггүй,
бүх морь нь хангал байсан боловч Овор адуугаа дуудчихвал адуу нь номхон,
өөрөө цутлаад ирдэг” гэж байсныг их гайхаж байсан гэв.¹⁸

5. **Баяндэлэгийг соёлын довтолгоонд оролцуулах оролдлого.** 1959–1963
оны хооронд Мөнххайрхан сумын “Оч” нэгдэлийн даргаар ажиллаж байсан
Түмэнжаргалын Даш гуай тэргүүтэн сумын удирдлагын хэдэн хүн Овор
хөгшнийг Индэрт гэдэг газарт шинээр байгуулсан сумын төвд ачааны машинаар
авчирч, шинэ соёлыг үзүүлэх, түүнийг соёлжуулах зорилгоор хэдэн хоног
байрлуулсан гэв. Ингэхэд насандаа биедээ саван хүргэж үзээгүй Оворыг халуун
усанд оруулж, урианхайн цагаан дээлийг нь тайлуулж хөвөнтэй ердийн монгол
дээл өмсгөж, эсгий тоокуу гутлыг нь шинэ арьсан гутлаар сольж түүний сахлыг
хусаж өгсөнд тэр бээр дараа нь “би сүрхий цагаан залуу болжээ” гэж өөрийгөө
гайхаж байв. Тэгэхэд “хүний юмыг мөнгөгүй яаж авах вэ” гээд мориноосоо
сайхан халтар морь нэгийг нэгдэлд бэлэглэсэн гэдэг.¹⁹ Үүний тухай Даш дарга
өөрийн тэмдэглэлдээ:

“Насан туршдаа хадны агуй, овоохойд сууж, бусдаас хоол хувцас
цуглуулан амьдарч байсан 69 настай урианхайн ястан өвгөн Овор гэгч
нэгэн өвгөнийг тэр үед шинээр хөгжиж байсан сумын төвд авч ирээд
халуун усанд оруулж, бүх хувцсыг нэгдлээс сольж өмсгөөд зочид буудалд
байрлуулан хооллож өдөрт албан газар танилцуулж, оройд кино үзүүлж
3-4 хоног үйлчлэхэд тэр өвгөн ухаарч Нам засаг гэдэг чинь ёстой биет хүн,

¹⁷ Мөнххайрхан сумын малчин Х.Лождой, Их Хотгор зуслан, 2012.6.29., бичлэгийн
дугаар WS560648, 12:46: Цөөхөн хүрэн адуутай ганц бие хөгшин байсан юм. Ганцаараа
их эзэнгүй газар нутагладаг. Айлаас нэлээн холхон зайтай, мал нь ердөөн нэг хэдэн
хэдэн хүрэн адуун байсан юм. ... Хааяа нэг айлд ирээд, Баянсайгийн айлууд[ад], гурван
дөрвөн хоноод дахиад буцаад явчихдаг гэрээр нь орж үзсэн, дэглээнд байсан байгаа. –
Мөнххайрхан сумын малчин Д.Очир, Их Хотгор зуслан, 2012.6.29., бичлэгийн дугаар
WS560651: Овор гэдэг хөгшнийг бас ойролцоо байж л байсан, хүүхэд байхдаа, мал хар
хариулаад, тэр байж байгаа газарт нь очиж байсан нэг муу насгар хар гэртэй, есөн
хүрэн морьтой. Бас их гоё гоё юм ярьдаг тийм хөгшин байсан юм. Нэг хоёр нэгхэн удаа
уулзаж байсан. Нэг муу ноорхой хар гэртэй байсан юм. ... Тэр хөгшин нэг есөн хүрэн
адуутай байсан, өшөө мал байгаагүй, айлууд хэсээд явж байдаг, баян айлуудаар хонож
өнжөөд тэгээд гэртээ очоод тэгээд амьдардаг байсан тэр хөгшин.

¹⁸ Булган сумын малчин, анчин С.Балдаа, 2012.5.11., бичлэгийн дугаар WS560603, 39:00.
¹⁹ Мөнххайрхан сумын иргэн Б.Ханджав, Баянсай, 2012.7.5., бичлэгийн дугаар WS560661
27:07.

манай Мөнххайрханы цастай мөнхийн том уул юм шиг зүйл байсныг одоо сайн мэдлээ гэж магтаж байжээ.²⁰

Овор хөгшнийг сумын төв дээр соёлжуулах, шинэ нийгэмтэй танилцуулах зорилгоор авчирсан гэсэн сонин мэдээ тухайн үед сумын хэмжээгээр өргөн яригдаж байсныг тэр үед сумын төвд эмчээр ажиллаж байсан Т.Манж гуайн дурсамж яриа баталж байна:

Ганцаараа байдаг Овор ахыг манай нэгдлийн Даш дарга авчраад халуун усанд оруулаад угаагаад бүх хувцсыг сольж өгсөн. Ирэхээр нь нэг хэдэн хүрэн адуутай байсан, нэгийг нь унаад нэгийг хөтөлж байхаар долоо наймыг дагаад яваад байдаг. Тэр хүрэн адуунаас нэг хүрэн өгсөн гэж байна шүү, нэгдэлд өгсөн юм. Бас ухаантай хөгшин байж. [Давтаж байна: Нэгдлээс түүнийг] авч одоод зочид буудалд, Индэрт гэдэг газарт, суманд авч одоод тэр хүнийг, цайлаад, дайлаад ч хоол унд хийгээд, бүр цайлга дайлга болоод гар хөлийг цайлаад бэлэг хачир өгөөд тэгээд дагаад тэр хүн дахиад тэр газартаа ганцаараа наашаа [ууланд] ирсэн.²¹

Ийм утгаар энэ явдлын тухай бас Дандарын Батсуурь дурсан ярив:

Тэр чинь нөгөө социализмийн үед дарга нар хэлцээд тэр Овор гэдгийг айл амьтан буудаггүй, хүнтэй уулздаггүй бараг зэрлэг болсон хүнийг одоо энэ комунизм гэдэг юмны хөгжил үзүүлдэг гэж авчирч байгаа ухаантай байхгүй юу. Тэр лав буудалд хонуулсан, кино гэж гоё юманд оруулсан, усанд оруулсан, ийм хөгжиж байгаа гэж энэ коммунизм энэ сайхан юм байдаг юм үзүүлж. Тийм нэг хэрэгт авчирсан юм. Авчраад буудалд авчраад их цагаан хөнжил тийм угаасан гайхалтай, тэр хүн бүр насандаа тэр хувцас гэдгийг угааж үзээгүй, зөвхөн тэр голын усанд хувцсаа мушгиад саван маван гэдэг юм биедээ хүргүүлж хувцсаа угааж үзээгүй. Тэгэхээр одоо ийм их сайхан нийгэм тогтож байна гэж түүнийг одоо авчирж үзүүлж тэр цагаан хөнжилд хэвтүүлсэн, тэгээд халуун усанд оруулсан гэж байгаа юм, тэр чухам шүршүүртэй халуун ус байгаагүй, ямар юмдаа оруулсан мэдэхгүй, тэр Индэрт гэдэг газарт байлаа. Тэгээд кино гэдэг юмыг үзүүлсэн тэгээд [гэрт нь буцаад] аваачсан боллоо.²²

6. Баяндэлэгийг сум нэгдлээс хатуу аргаар байцаасан тухай. Овор хөгшнийг сумын төвд авчирсан тухай сонирхолтой мэдээ тухайн үед сум даяараа тарж байсныг олон хүний ижилхэн аман түүхийн дурсамж гэрчилж байгаа юм. Гэхдээ Овортой ойр дотно байсан Б.Ханджав, Оворын ахын ач охин Поолуугийн Ноосгой нарын ярьснаар сумын удирдлагаас Оворт хандсан

²⁰ Бөхөө, Цэрэнгийн. 2007. Түүх бүтээлцсэн ард түмэн минь. Ховд, х. 146.

²¹ Мөнххайрхан сумын эмч Т.Манж, Шуурхай нууруудын зуслан, бичлэгийн дугаар WS560656, 2012.7.2., 14:39.

²² Мөнххайрхан сумын уугуул Д.Батсуурь, Ховд аймгийн төв, 2013.7.24., бичлэгийн дугаар WS561004, 8:33.

сонирхол үүгээр зогсоогүй. П.Ноосгойн хэлснээр дарга нар Оворыг цайлах далимаар сумын төвөөс мөстэй газарт дагуулаад, хүчээр нүцгэлээд, дээрээс нь ганцхан дээл нөмөргөж хаячхаад, мөсөн дээр суулгаад байцааж эхэлсэн гэнэ: “Чи хэнийд ном уншлаа? Чи хэнд мэргэ тавилаа? Түүний өргөлд юу авлаа?” гэж байцааж байхад нүцгэн бие нь чичирч эхэлсэнд түүнийг босгоод мөсөн дээр гүйлгэж дулаацуулж дахиад суулгаад байцаасан гэнэ. Тэгээд түүнийг “нэгдлийн хурал дээр суу, хүнийг нэгдэлд оруул” гэж шаардаж байсан гэнэ. Нэгдэлжих хөдөлгөөн биелснээс хойш зарим хүн “Овор ах уриалаад амьтан бүгд нэгдэлд ирсэн” гэж хэлцдэг байсан гэнэ.²³

Б.Ханджавын өгүүлснээр уг явдал эсрэг дэс дараатай болов. Ханджавын дагуу Овор өөрөө хэлэхдээ: “Чулуун дарга намайг хайж ирээд тэгээд аваад явсан, тэгээд намайг М. [Ондрей Срба товчлов] гэдэг төлөөлөгч: Чамайг амьтанд тусалж байна гэнэ. Амьтны нүүр гарыг нь угааж байна гэнэ. Амьтны өвдсөн барьсан хөвүүг сэргээж байна гэнэ.” Тэгээд нэг хотгор газарт авчраад байцаалаа гэнэ. “Тэгэхээр би дуртайдаан тэгээгүй. Олон түм [= түмэн олон] намайг эс амруулахаар ядарсан зүдэрсэн амьтан арга ядаад, мэддэгээ хийж байсан үнэн гэж хэлэв.” Тэгээд байцаалтын дараа түүнд шинэ дээл, гутал өмсгөж гэрт нь явуулсан байна гэв.²⁴

Гэвч Овор хөгшнийг хатуу аргаар байцаасан үйл явдал тухайн үед түүний хамгийн ойрхон төрөл садан, танил айлуудын хүрээнд дуулдаад зогсоогүй Булган суманд амьдарсан С.Балдаа ч тус учир явдлыг дурдахдаа үүнийг Оворын биеийн байдал хүндэрсний гол шалтгаан болов гэж үзэв.

Хойно түүнийг суман дээр гэр орон барчихна, нэгдэл, тэнд асраад [байлгана гэж яриа гарч байсан]. Сэнхэрийн М. гэж дарга байсан гэнэ. Тэр [Оворыг] мөсөн дээр суулгаад, мөсөн дээр байцаад өвөл цагт, тэрнээс хойш муудаж одлоо, тэгээд яваад тэгээд нас барсан юм.²⁵

7. Баяндэлэгийн бурхан шүтээнийг нуурын усанд шидсэн нь. Баяндэлэг хатгууртаа 50, 60-аад оны үед ч гэсэн ил тавигдсан элбэг бурхан шүтээнтэй байж, тэдэнд өдөр болгон цөгцтэй тахил тавьж байдаг байжээ. Овортой ойр дотно явсан Ханджав эмгэн түүнийг догшин сахиусыг тахидаг, тодорхойлбол Улаан сахиус буюу Улаан ядам, Гомбо буюу Хар Махгал, Лхам Сэндэн, Ногоон Дарь эх зэрэг бурхныг тахиж байсан гэв. Ханджавын хэлснээр Овор лам биш хар хүн боловч төвд номыг амаар (цээжээр) орчуулах чадвартай байв. Хойморт сураар чанга боосон үсэн ууттай. 1950-аад оны үед нэг хүүхэд Овор хөгшний эзгүйд хатгуурт нь орж түүний бурхан шүтээн, номыг нь булааж Нарийн

²³ Мөнххайрхан сумын иргэн П.Ноосгой, сумын төв, 2011.7.13., видео бичлэгийн дугаар 27, 03:07–05:10.

²⁴ Мөнххайрхан сумын иргэн Б.Ханджав, Баянсай, 2012.7.5., бичлэгийн дугаар WS560661 27:07.

²⁵ Булган сумын малчин, анчин С.Балдаа, Гүүтийн ам, 2012.5.11., бичлэгийн дугаар WS560603, 42:10.

цүнхгийн нуур луу шидчихсэн гэж хэдэн хүн санаа нийлж байна. Овор энэ хүүхдийг загнасан ч “би хүний амь авахгүй, гэвч энэ хүүхэд дунд насандаа нэг зовно, гэвч өвчин гэмтэхгүй”. Энэ хүнд дараа нь хэцүү өвчин тосоод мээ заслаар амжилттай эдгээсэн байна. Тэгээд Овор хөгшин шүтээн бурханаа Ховдын Булган суманд байсан Торгуудын Вангийн хүрээнээс биеэрээ очиж шинээр залж авчирсан гэдэг.²⁶

Нас хөгширснөөс хойш Овор хэвээрээ ганцаараа хатгууртаа амьдардаг байсан бөгөөд зөвхөн тодорхой хэдэн айлуудаар ордог байв. Гол очдог айл нь Бишээ, түүний эхнэр Ханджав нарын айл байв. Ханджав гуай гэртээ ганцаараа гэрийн ажил хийж байхад Овор түүнд элдэв зүйлийн хууч яриа, домог түүх, сургаал сургамж, цаашлаад бүр тууж тууль хэлдэг байсан гэнэ. Ханджав түүнээс юм лавлаж асуудаггүй, тэр өөрөө ярьж өгдөг байсан ч Ханджав гуай бүхний маш сайн цээжилж тогтоодог байлаа. Хүн орж ирэхээр Овор гэдрэгээ харж чимээгүй хэвтэнэ.

Сүүлийн жилүүдэд Овор хоёр нүд сохор болж ахынхаа хүү Поолуугийнд хонодог болсон ч хамаг сүүлд өвлийн үед Бээвэй гэдэг газарт хатгууртаа хүнээс далд таалал төгсжээ. Оворын ном түүний нас барсан газар дээр үлдэж хоцорсон гэнэ.²⁷

8. Овор Баяндэлэг гэж хэн байв? Энэхүү илтгэлд танилцуулсан Овор Баяндэлэгийг үзэхэд бичгийн сурвалж огт байхгүй хүний тухай аман түүх, аман уламжлалын мэдээллийн нарийн харьцуулсан судалгааны аргаар нэлээд бүрэн намтрыг сэргээж болох юм. Мэдээж бидэнд хүрч ирсэн мэдээлэл бол тус хүний жинхэнэ түүхт намтар биш, гэвч энэ хүний тухайн газрын ард түмний нийтийн дурсамж, ой тогтоолд үлдээсэн аман түүхийн дүр юм.

Тийм учраас Овор Баяндэлэг чухам хэн байв гэсэн асуудал өөрийн эрхгүй тулгарч байна. Энэ асуултыг хариулахад төвөгтэй ба эцэслэн шийдвэрлэх боломжгүй. Аман түүхийн мэдээг дамжуулсан хүмүүс Овор Баяндэлэгийг хэн гэж ойлгож байсныг л хариулж болно.

Овор хөгшнийг гэртээ хамгийн их хүлээн авдаг байсан Б.Ханджав Оворыг түүний хийж байсан үйлдлээр нь тодорхойлон ярьдаг байв. Овор бол хүүхэд ба том хүний өвчнийг эдгээдэг, хүнд тусах аливаа гай зовлонг арилгадаг, эрих барьж мэргэлдэг, хаяа хүнд ном уншдаг хүн байсан гэж ярив.

Хүн хүнд өвдөхөөр юм тарнидаад, их ном уншаад, нүүр гарыг нь юмаар угаагаад, тэгээд туслаад байдаг байсан шүү. Одоо энэ жаахан

²⁶ Мөнххайрхан сумын уугуул Д.Батсуурь, Ховд аймгийн төв, 2013.7.24., бичлэгийн дугаар WS561004, 2:29. Энэ учир явдлын тухай бас Б.Ханджав, П.Ноосгой нар ярив.

²⁷ Бурхан ном нь түүний буур дээр хаягдсан билээ. Мөнххайрхан сумын өндөр настан Б.Ханджав, сумын төв, 2011.7.13., бичлэгийн дугаар WS560403, 12:34.

Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл

хүүхэд халуураад бариад гэдэс нь өвдөхөөр тэгээд туслаад байдаг байсан. Чадалтай хүн байсан.²⁸

Тийм хүнээс тийм юм авсан, чамд гай болж байна, таарахгүй гэх жишээтэй юмыг. Чиний гар барьж үзнэ, хэдэн хоногоос түүрүүн тэдэн хоногоос сүүлд чамд тэр зүгээс тийм юм ирчихнэ [гэж хэлдэг байсан]. Хүүхдийн шээс аваад ингээд модоор ингээд л хутгаад нүд муутай [хүн байсан болохоор] ийгээд [гараар] саравчлаад наранд халайгаад [= хараад] байгаад тийм янзтай авсан байна шүү, тийм юм байна гэж хэлж байсан юм. Их чадмаг хүн байсан.²⁹

Эрих барьж үзнэ, чулуу тасална, хумлага [= ховлог] тавина, янз бүрийн. Хүнээс нууц ямар юм [= арга] болдог юм хээр гарна дээл гүвнэ гээд гараад явдаг юм тэгээд тун юм үзэж байсан юм шиг юм хэлнэ.³⁰

Овор бас малын өвчнийг зогсоох чадалтай байсан гэнэ. Нэгдэлд орсноос хойш Б.Ханджав албан журмын сүүний норм хэмжээнд хорин үхрийн сүү саадаг байсан. Нэг жил түүний төрдөг үхрийн тугал үхээд байснаас тэр албан журмын сүүгээ яаж гүйцээх вэ гэж санаа зовж байтал Овор ах ирж усанд жаахан сүү тусааж байгаад өргөөд, хар усаар сэржим өргөсний үр дүнд тугал сэргээд, ард нь төрсөн үхрийн тугал үхээгүй билээ.³¹

Мөнххайрхан сумын төр захиргааны ахмад ажилтан Санзайн Сонинтөр (1928–2016) Оворыг “жаахан номтой, ном уншдаг, юм мэддэг [хүн], мэргэн гэж нэрлэгдсэн, шар биш, хар туслалцаа амьтанд үзүүлдэг” гэж хэлэв.³²

Мөнххайрхан сумын малчин Шарын Уламбаяр Оворыг “номтой хөгшин, юм мэддэг хүн, лам, эмч, арга домтой хүн” гэж тодорхойлов.³³

²⁸ Мөнххайрхан сумын өндөр настан Б. Ханджав, сумын төв, 2011.7.13., бичлэгийн дугаар WS560403, 10:00.

²⁹ Мөнххайрхан сумын өндөр настан Б. Ханджав, сумын төв, 2011.7.13., бичлэгийн дугаар WS560403, 13:17.

³⁰ Мөнххайрхан сумын өндөр настан Б. Ханджав, сумын төв, 2011.7.13., бичлэгийн дугаар WS560403, 14:16.

³¹ Мөнххайрхан сумын өндөр настан Б. Ханджав, сумын төв, 2011.7.13., бичлэгийн дугаар WS560403, 14:57.

³² Мөнххайрхан сумын өндөр настан С. Сонинтөр, 2012.6.30., Хөхгол, Сонинтер бичлэгийн дугаар WS560652, 34:28: Гэр булгүй ганц хөгшин, Цүнхгийн тухарт цас ордоггүй газарт жаахан гэртэй. Жаахан номтой, ном уншдаг шашны [ном]. Юм мэддэг, мэргэн гэж нэрлэгддэг, айлуудаар жуулчлаад хоноод өнжөөд явж оддог. Хумүүс асуугаад ирээд тийм хүн өвдөж байна, ийм мал алдаж байна, мэргэлүүлэхгүй юу. Хүүхэд мүүхэд өвдөхөд мэргэлээд бариад өгдөг.

³³ Мөнххайрхан сумын иргэн Ш. Уламбаяр, Их Хотгор, 2012.6.29., бичлэгийн дугаар WS560646, 34:39: Ганцаараа хатгуур гэдэг юм дотор хэдэн хүрэн адуутай самгангүй, ганц тийм хөгшин байсан Овор гэдэг хөгшин, номтой хөгшин байсан шүү дээ, дээр үеийн юм мэддэг.

Юм мэддэг хүн, молда, юу гэж хэлдэг юм, лам хүн байсан, эмч гэдэг юм их ховор байсан тэр үед, хүнд их тус болдог, эмчилдэг, хараар, тийм хүн байсан, тийм хүн байсан тэр Овор гэдэг хүн. Хүний хүүхэд гарахгүй болохоор гаргадаг, тийм ийм илдэг барьдаг, янз бүрийн арга домтой тийм хөгшиг байсан.

Мөнххайрхан сумын аварга эмч Түнжингийн Манж (1933-?) Оворыг “лам хүн, номтой, эрдэмтэй хүн” гэж тодотгон яриу.³⁴

Мөнххайрхан сумын малчин Хуухнагийн Олзвой (*1941) Овор хөгшнийг “одоо байсан бол сайн лам байх билээ ... угаасаа лам байж байгаад эсэргүү баригдах дээрээ хар болоод” явсан хүн гэж дурсан яриу.³⁵

Мөнххайрхан сумын Бортын Хөхнуурт зусдаг байсан өндөр настай алдарт ээж Сосор Овор хөгшнийг “аюултай сайн цээжтэй, хуучны номтой ... амьтанд тусалдаг тийм лам хүн байсан” гэж дурдав.³⁶

Мөнххайрхан сумын уугуул өндөр настан Дандарын Батсуурь Овор хөгшинтэй хүүхэд насандаа олон удаа уулзаж түүнийг “нэгдүгээрт зурхайч хүн – хүрээний ямар ч лам түүнд хүрдэггүй байсан – хоёрдугаарт [номын өндөр мэдлэгтэй хүн] – ном хаялцаад лам нар бас бараагүй юм гэнэ – дээрээс нь мэргэ төлгө тавьдаг тийм хүн байсан, мэргэ төлгө тавихдаа бүр онцгой ... тарвагний дал түлээд мэддэг, хэлсэн зүйл нь бүгд таарч байсан. Хоёрдугаарт бас харын домтой хүн байсан” гэж Оворын эрдэм чадлыг маш өндрөөр үнэлэв.³⁷

Ямар нэг өвчин тусахаар хүнийг үлээдэг, хүнийг ингэж илж барьдаг, өшөө хүнд эм тангийг, өвс өгдөг байсан, [тэр үед] эм байгаагүй, янз бүрийн эмийн ургамал, цэцгээр хүнийг эмчилдэг, тийм хөгшин байсан, дээр үеийн хатгуурт суудаг, самгангүй хөгшин, хүүхэдгүй ганц хөгшин, юм мэддэг.

³⁴ Мөнххайрхан сумын иргэн Т.Манж, Шуурхай нуурууд, 2012.7.2., бичлэгийн дугаар WS560657.

³⁵ Мөнххайрхан сумын иргэн Х.Олзвой, Шуурхай нуурууд, 2012.7.2., бичлэгийн дугаар WS560658, 9:35: *Тэр лам хүн байсан, дээр үед лам байж байгаад тэгээд үлдэж одсон. Самган аваагүй. Одоо байсан болжим [= болвол] сайн лам байх билээ. Дээр үед лам байж байгаад эсэргүү баригдаад ирэхээр харлаад ... Баянсайгийн Нарийн цүнхэг гэдэг газарт дан зусдаг, өвөл зун нэг л газарт байна. Өвөл орохоор айл хэсээд, айл хэсээд хэд хоночихоод хатхууртаа [буцна], тэнд хэд хононо, хэвтэнэ. Тэгээд бичкэн [= бага зэрэг] сайн дур нь хүрэхээр айл хэсээд хэд хоноод л ... Нэг д газар тав зургаан жил боллоо. ... Болошигүй болохоор хүн амьтан өвдөхөөр ном сом уншиж өгнө, тийм юмаар тусалдаг байсан.*

...Тэр зүгээр нэг жирийн хөгшин байхаас биш тэр хардаж [= харлаж] ... хэлмэгдэлд орж байгаагүй, угаасаа лам байж байгаад эсэргүү баригдах дээрээ хар болоод. Угаасаа эхнэр аваагүй ганц хатгууртай хөгшин ганцаараа ...

³⁶ Мөнххайрхан сумын өндөр настан Сосор, Хөхнуур, 2012.7.3., бичлэгийн дугаар WS560660.

³⁷ *Хүүхэд тогтоддгүй бүр ийм хүнийг Захчин хошууны хамгийн том лам нар байж байхад тэр Овор гэдэг хүнийг авчирсан. Тэр хүн нэг чадвал чадна. Тэр [хүнийг] авчиртад тэгээд хүүхэд тогтоосон одоо энэ Н. Б. [Ондрей Срба товчлов] гэдэг нэг авгай байж, тэрнийг тогтоосон. Тийм хүн байсан. Түүрүүчийн нэг хүүхэд яг өнгөрөх гэж байхад авчиртад: За, энэ одоо хугацаа өнгөрч байж, би чадахгүй [гэж хэлэв]. Дараачийн хүүхэд бол болно, [би тогтоож чадна.] гэсэн. Дараачийн дахиад нөгөө авгай жирэмсэн болоход нэг үзүүлээд энэ одоо хугацаа өнгөрч байж, би чадахгүй [гэж хэлэв]. Дараачийн хүүхэд бол болно, [би гарсан доор нь [Оворыг] авчиртад тэгээд энэ бараг хамрын ханиад тусалгүй тийм [насаараа эрүүл] хүн болсон. Нэлээд алдартай хүн байсан гэж хэлдэг юм. Мөнххайрхан сумын уугуул Д.Батсуурь, Ховд аймгийн төв, 2013.7.24., бичлэгийн дугаар WS561004.*

Овортой хоёрхон удаа уулзсан ч ер нь нутагт болсон аливаа юманд их сэрэмжтэй, сонсож дуулсан бүгдийг маш сайн цээжлэдэг байсан Булган сумын малчин С.Балдаа гуай өмнө дурдсанчлан Баяндэлэгийг Алтайн савдагтай нөхөрлөн ханилдаг хүн гэж ойлгоод түүнийг Алтайн савдгаас ер бусын мэдлэг чадвартай гэж ярьдаг байв. Балдаа Оворыг дал түлээд далны төлгө хэлдэг байсан гэж дурдав. Овор цаг шинжих, сайн муу өдрийн үзлэгэнд гарамгай байсныг Балдаа дараах явдлаар гэрчлэн ярив:

[Овор] залуу цагт нь айлд тариа татаж сууж гэнэ. Тэр бага залуу тэр айл баян айл зарц болоод сууж байхгүй юү? Тариа [тээрэмдэн] татаж байдаг, нэг том лам орж ирэв гэнэ, хүрээгийн том лам. [Тэгээд тэр гэрийн хүн]: “Оо гэнгэй, гэнгэй, юун сайхан санж, гэнгэй. Сайн, сайн.” Одоо цай чанаад хоол архи өгөөд, ламаа тоогоод: “Оо гэнгэй, энэ хөвүүний даахь авна бид, түүний өдөр зааж өгтөн” гэж тэгж хэлэв. Тэр ламаас тэр айлийн эзний авгай тэгж [асууж] байхгүй юү? Тэр [лам] эрихээ бариад тэр сарын тэр өдөр даахь ав гэж хэлэв лам. Тариа татаж байсан Овор: “Тэр өдөр нь болдог юм уу, лам?” гэж ингэж [хэлсэн] тэр Овор, “тэр өдөрт хүний даахь авдаг юм уу?” Тэгсэн гэнэ. [Лам нь уурлаад]: “Чи мэдээд [байвал] өдөр цаг зааж өг” [гэж] давирсан хөвүүг, залууг [= Оворыг]. “Уу, би мэддэггүй хөгшин яаж мэддэг болов уу?” [гэж Овор ламын уурыг дархаар хэлэв.] Тэгээд ламын үгээр тэр өдөр тэр хөвүүгийн өрлөг авсан тэр айл бүтэн тараад бутраад [юу ч үгүй хоосон болов].

Тэр сууж байтал тийм [юмыг] мэддэг байсан байгаа. Тэр Алтайн савдаг хэлсэн, тэр Цаст цагаан уулын цагаан өвгөн, Хүрэн улаан уулын савдаг тэр одоо ханьчиж [= ханилаж] байсан байхгүй юү?

Нэг хүн гурван жил манай энд ууланд юм уу хүн амьтантай харгалдалгүй [= уулзалгүй] гурван жил ууланд байдаг юм, заавал нэг юм ханьчдаг [= ханилж нөхөрлөдөг] юм гэлүү. Савдаг тэр сайн, шулам муу. Тийм түүхтэй юм.³⁸

Булган сумын Зодовын Тавитай (*1937), Намралын Оролмаа нар Овор хөгшний тухай ярихдаа С.Балдаагийн дүгнэсэнтэй нэгэн адил түүнийг Алтай эзэн, савдагтай холбоотой, газрын эзнээс зөн билгийн чадвараа олсон хүн гэж илтгэв. “[Овор] ганцаараа байдаг билээ. Баян Алтайгаас юм мэддэг, зөн билиг мэддэг хүмүүсийн ярьдгаар сонсож байхад ... эзтэй болдоггүй юу ганцаараа байгаад ... тэр юмтай хүүндэдэг л байсан, байгалийн юмтай, байгал дэлхийн эзэнтэй харьцдаг байсан ... уул нь лам хүн байгаад тэр эзгүй ууланд ганцаараа байгаад тэр эзэн харьцсан шиг байна.”³⁹ Тэгээд дарга нар Овор хөгшнийг сумын

³⁸ Булган сумын малчин, анчин С.Балдаа (1933–2015), Гүүтийн ам, 2012.5.11., бичлэгийн дугаар WS560603, 49:55.
³⁹ Булган сумын малчин З.Тавьтай, эхнэр нь Н.Оролмаа, Хөх Толгойт, 2012.5.15., бичлэгийн дугаар WS560620, 53:00.

“БНМАУ: Буддын шашин, сум хийдийн асуудал” (1944-1990 он) —
төвд авчирснаар газрын эзэн түүнийг орхиж хаясан гэнэ (Тэр ханьчуур юм тэр
нь [түүнийг] хаяж өгсөн шиг байна.).

Дүгнэлт

Баяндэлэг нутгийн малчдын дунд алдартай, аман уламжлал нь өнөө хүртэл амьд байгаа боловч Мөнххайрхан сумын тухай хэвлэлээр гарсан аль ч номд түүний тухай зохих тэмдэглэл байхгүй.

Баяндэлэгийг нэг үгээр тодорхойлон тодотгох боломжгүй. Алтайн уултай тахин шүтлэгийн барилдлага, амьдралын хэв маягаараа Овор хөгшин хорьдугаар зууны Алтайн Урианхайчуудын дунд ганцаараа биш байв. Дуут сумын алдарт цуурч (цоорч) Паараан Наранцогт (1924–2003) өөрийн ярьсан аман түүхийн дагуу Алтайн эзний үгээр 1973 онд төрсөн Буянт сумаас Дуут суманд нүүж очоод тэнд “дуртай цагтаа цоор татаад Алтайн эзэнтэй уулзаж болдог болсон” гэв. “Мөнххайрхан ууланд ирээд бүхий л газраас рашаан, эмийн ургамал гарна гэж захив. Анхлан энэ газрын савдаг догшроод оруулахгүй гэж байсан. Гэвч ярилцаад “хүмүүсийн асуусан зүйлийг хэлж өг, өөрийн дураар юм ярьж болохгүй, хүнээс өргөл барьц бэлэг сэлт авч болохгүй” гэж захиад нутаглахыг зөвшөөрсөн.”⁴⁰ Дуутад нутагласнаас хойш Наранцогт Алтайн эзний тусламжтайгаар олон хүнийг өвчнөөс салгаж, зудын гарз хохирлыг багасгаж, хүүхэдгүй айлыг хүүхэдтэй болгосон зэрэг Овор хөгшинтэй адилхан аргаар ард түмэндээ тусалж байсан гэнэ.

Бас Буянт сумын Хойт Хөлцөөтийн ядуу анчин Шээмээ (20-р зууны 80-аад оны үед бурхан болсон) гэдэг хүнтэй харьцуулбал Овор хөгшний аман уламжлалын дүр их ойролцоо байна. Тэр бээр ан агнаж байтал Алтайн эзэнтэй уулзаад түүнээс ер бусын чадал мэдлэгийг олсон. Түүний үүрэг нь “Алтайн савдагтай харьцаж түүнийг тайвшруулж номхруулж байх” гэж байсан.⁴¹ Нутгийн хүмүүс Шээмээгийн тухай ярихдаа “савдгийн хэл мэднэ, Алтайн савдагтай уулзаад мөргөөд ... түүнтэй ярьна, хэлийг нь мэддэг болоод, номыг нь мэддэг болоод, тэр савдаг ирдэг, өөр хүнтэй ярихгүй”⁴² гэж түүнийг онцгойлон хүндэтгэж байна.

Эд бүгдээрээ тухайн газрын ардыг Алтайн уулын эзэн савдагтай холбон харилцаж өгдөг байсан. Ийм хүмүүсийн тухай аман түүх, аман уламжлалыг цаашид нь анхаарч судалбал Ойрадын шашин шүтлэгийн уламжлалд онцгой байр суурийг эзлэх нэг бүлэг түүхт хүн гарах магадлалтай гэж урьдчилан дүгнэж байна.

⁴⁰ Ганболд, Орьяс Мөнгөнхүүгийн. 2017. *Ойрад Монголын угсаатны зүйн хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүн (1986-2016)*. Нэгдүгээр боть. Улаанбаатар: СУИС СУСХ – ХИС НХУС, х. 67.

⁴¹ Баян-Өлгийн аймгийн Алтай сумын дарга асан Лишээ, 2014.6.26., бичлэгийн дугаар WS561243, 01:08:59.

⁴² Баян-Өлгийн аймгийн Буянт сумын малчин П.Энх, 2012.7.12., бичлэгийн дугаар WS560685, 1:07:50–1:09:21.


Acknowledgment: This publication was made possible with the support of the Czech Science Foundation within the project GA19-07619S: Mongolian ritual manuscripts in a Czech collection: their edition, history and Central Asian roots.

Зохиогч Мөнххайрхан, Булган сумын мэдээлэл өгөгч бүх иргэдэд гүн талархлаа илэрхийлж байна.

Ном зүй

1. Srba, Ondřej – Gegeenhas. 2011. Noms' Bayandeleg (1891–1967): The oral history of a mysterious hermit from Мцннhairhan. *Mongolo-Tibetica Pragensia* '11 4/2, x. 69–91.
2. Srba, Ondřej. 2015. A Collection of Clear Script Manuscripts of S. Naadgai and the Continuity of Clear Script Usage in Oirat Religious Life. In: *Linguistica Brunensia* 63/1 (2015), x. 37–56.
3. Баатар, Б. 1999. *Булган нутгийн буянтай буурал*. Булган
4. Балданжав, Р. 2016. Урианхайн Дашчойнхорлин хийдийн өнөөгийн байдал. In: *Баруун Монголын шашин соёл*. Эмхэтгэж, эрхлэн хэвлүүлсэн На.Сүхбаатар, Г.Ядамжав. Улаанбаатар: Тод номын гэрэл төв, x. 180.
5. Бөхөө, Цэрэнгийн. 2007. *Түүх бүтээлцсэн ард түмэн минь*. Ховд.
6. Ганболд, Оръяс Мөнгөнхүүгийн. 2017. *Ойрад Монголын угсаатны зүйн хээрийн судалгааны эх хэрэглэгдэхүүн (1986-2016)*. Нэгдүгээр боть. Улаанбаатар: СУИС СУСХ – ХИС НХУС.
7. *Есөн аравны цадиг*. 2017. (Ховд аймгийн Мөнххайрхан сумын 90 жилийн ойд зориулав.) Эмхтгэн боловеруулсан С.Бүрнээ (et col. ...). Улаанбаатар.
8. Срба, Андрей. 2018. Монгол улсын Алтай Урианхайчуудын тод үсгийн хэрэглээ (Аман түүхийн судалгаа). In: *Тод үсэг – 370*. Эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн Эмхэтгэл. Эмхтгэж, эрхлэн хэвлүүлсэн На.Сүхбаатар. *Bibliotheca Oiratica LXXVII*. Улаанбаатар: Тод номын гэрэл төв, x. 24-34.
9. Аман түүхийн дууны бичлэгүүд: зохиогчийн хувийн архив.

Холбогдох гэрэл зураг



Зураг 1. “Овор” Баяндэлэгийн байрлаж байсан Нарийн цүнхэг нуур



Зураг 2. “Овор” Баяндэлэгийн сууж байсан Бугат нуурын дэргэдэх буурь



**БНМАУ: БУДДЫН ШАШИН,
СҮМ ХИЙДИЙН АСҮҮДАЛ
(1944-1990 ОН)**

Улаанбаатар хот
2021 он



ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ТҮҮХ,
УГСЛАТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭН



ГАНДАНТЭГЧЭНЛИН ХИЙДИЙН
ЭРДЭМ СОЁЛЫН ХҮРЭЭЛЭН

“БНМАУ: БУДДЫН ШАШИН, СҮМ ХИЙДИЙН АСУУДАЛ”

(1944-1990 ОН)

(Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл)

Эмхэтгэсэн: Магистр Г.Цэрэнсугар

УЛААНБААТАР ХОТ
2021

ННА* 86.35
ДАА** 294.3
Б-823

ШУА-ИЙН ТҮҮХ, УГСААТНЫ ЗҮЙН ХҮРЭЭЛЭНГИЙН
ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ЗӨВШӨӨРСНӨӨР ХЭВЛЭВ.

“БНМАУ: Социализм ба бурхны шашин” (ШуСс-2019/59) суурь судалгааны
төслийн хүрээнд “БНМАУ: Буддын шашин, сүм хийдийн асуудал” (1944-
1990 он) сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулав.

“БНМАУ: БУДДЫН ШАШИН, СҮМ ХИЙДИЙН АСУУДАЛ” (1944-1990 ОН)

(Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл)

Эмхэтгэн хэвлүүлсэн: Г.Цэрэнсугар
Хэвлэлийн эх бэлтгэсэн: П.Номинцэцэг
Хавтасны дизайнер: У.Билэгт-Од
Цаасны хэмжээ: 70x100/16
Хэвлэлийн хуудас: 18.3 х.х
Хэвлэсэн тоо: 300 ш
Хэвлэлийн “Соёмбо Принтинг” ХХК-д хэвлэв.

ISBN 978-9919-9646-8-9

© Зохиогчийн зөвшөөрөлгүй хэвлэн олшруулахыг хориглоно.